



МОНГОЛ-ОРОСЫН
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН НИЙГЭМЛЭГ
УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/281

Улаанбаатар хот

Ачилт, буулгалтын ажлын хөлсийг
шинэчлэх тухай

Хувь нийлүүлсэн нийгэмлэг “Улаанбаатар төмөр зам”-ын дүрмийн 22 дугаар зүйлийн “а” заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Ачилт, буулгалтын ажлын хөлс”-ийг хавсралтаар шинэчлэн баталж, 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхдээ холбогдох ажилтнуудад зааварчилгаа өгөх, зохих программ хангамжид өөрчлөлтийг оруулах, үйлчлүүлэгч нарт мэдэгдэхийг Эдийн засаг, санхүү хариуцсан замын орлогч дарга бөгөөд Санхүү, нягтлан бодох бүртгэлийн албаны дарга (С.Я.Усольцева), Төлөвлөлт, эдийн засгийн албаны дарга (З.Энхбаяр), Тээвэр зохион байгуулалтын албаны дарга (Б.Мөнхтулга), Статистик бүртгэлийн төвийн дарга (Д.Тамир), Мэдээллийн технологийн албаны дарга (Х.Анар) нарт даалгасугай.

3. Энэхүү тушаалыг баталсантай холбогдуулан Замын даргын 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/230 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалын биелэлтэд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг Тээвэрлэлт, хөдөлгөөн хариуцсан замын орлогч дарга (Д.Амарбаясгалан)-д даалгасугай.

ДАРГА



Х.ХЭРЛЭН

1601251752

“УБТЗ” ХНН-ийн даргын 24-ны дүгээр
сарын 04-ны өдрийн 381 дугаар
тушаалын хавсралт



АЧИЛТ, БУУЛГАЛТЫН АЖЛЫН ХӨЛС

А. Механикжсан аргаар

Хүснэгт 1. Ачааг ачих, буулгах ажлын хөлс

дд	Ажил	Хэмжих нэгж	Ажлын хөлс, төгрөг	
			ачих	буулгах
1	Шанагат авто ачигч (трактор, ковш зэрэг)-аар нүүрс болон бусад нурмаг ачааг автомашин ба вагонд ачих	1 тонн	5000	-
2	Авто ачигчаар ачаа ачих буулгах	1 тонн	5000	5000
3	Хосолсон арга (механикжсан болон гар арга)-аар ачих, буулгах	1 тонн	6500	6500
4	Цахилгаан өргүүр, автокранаар вагон ачих, буулгах	1 тонн	5000	5000
5	Өөрөө явагч авто өргүүр, механизмаар ачих, буулгах	1 тонн	7000	7000
6	Ачмаг, биг-бэгт савласан ширхэгийн ачаа (цемент, тоосго, гөлтгөнө, блок зэрэг) –г ачих, буулгах	1 тонн	5000	5000
7	Өндөрлөсөн замын нурмаг ачааг ачих, буулгах	Хоппер, думпкараас	1 тонн	-
		Хагас вагоноос	1 тонн	-
8	Автомашинаас автомашинд ачааг шилжүүлэн ачих	Машин механизм, техник	1 өргөлт	70000
		Тоног төхөөрөмж	1 байр	53000
		Чингэлэг	1 чингэлэг	40000

Хүснэгт 2. Чингэлгийг ачих, буулгах ажлын хөлс

дд	Чингэлгийн төрөл	Хэмжих нэгж	Ажлын хөлс, төгрөг	
			ачих	буулгах
1	20 фут хүртэлх чингэлэг	1 чингэлэг	20 000	20 000
2	20 футээс дээш чингэлэг	1 чингэлэг	40 000	40 000

Хүснэгт 3. Чингэлэг, вагоныг гаалийн үзлэгт бэлтгэх нэмэлт ажлын хөлс

дд	Ажил		Хэмжих нэгж	Ажлын хөлс, төгрөг
1	Чингэлэг зөөвөрлөх	20 фут хүртэлх	1 чингэлэг	33 000
		20 футээс дээш	1 чингэлэг	65 000
2	Чингэлгийг гаалийн үзлэгт бэлтгэх	20 фут хүртэлх	1 чингэлэг	48 000
		20 футээс дээш	1 чингэлэг	95 000
3	Вагоныг гаалийн үзлэгт бэлтгэх		1 вагон	95 000

Тайлбар:

- 4 голт вагоны ачааны жинг бодох хамгийн бага жингийн нормыг 20 тонноор тооцно. (хүснэгт 1, 2, 3-т хамаарна)
- Ачилт, буулгалтын хөлсийг дараах тохиолдолд 100 хувиар нэмэгдүүлэн тооцно. Үүнд: (хүснэгт 1, 2, 3-т хамаарна)
 - Нунтаг, нурмаг ачаа нь хөлдүү байвал;

2.2 Тэсрэх дэлбэрэх аюултай, хортой ачаа.

3. Ачилт, буулгалтын хөлсийг дараах тохиолдолд 50 хувиар нэмэгдүүлэн тооцно. Үүнд: (хүснэгт 1, 2, 3-т хамаарна)

3.1 Ачилт, буулгалтын техникийн шаардлага (баглаа боодолгүй, хайрцаггүй задгай, задарсан эсвэл зориулалтын өргөх оосорлох хэрэгсэлгүй, ачаа хооронд ивүүр жийрэггүй) хангаагүй ачаа.

4. Илгээгчийн мэдүүлсэн ачааны жинг үндэслэн бодох ба 1 тонн хүрээгүй жинтэй ачааг 1 тонн ачаагаар бодно. Ачилт, буулгалтын үед илгээгчийн мэдүүлснээс өөр нэр төрлийн ачаа гарах, жин нэмэгдэх тохиолдолд мэдүүлэгт нэмж бичүүлж нийт жингээр тооцно. (хүснэгт 1, 2, 3-т хамаарна)

5. Хэрэв хэд хэдэн төрлийн ачилт, буулгалтын үнэлгээтэй ачаа нэг вагонд ачигдсан бол ачааны төрлөөр жинг бүхэлчлэн үнэлгээ тус бүрээр ачилт, буулгалтын хөлсийг бодож, тэдгээрийн нийт дүнгээр үнийн дүнг гаргана. (хүснэгт 1, 2, 3-т хамаарна)

6. Үйлчлүүлэгчийн хүсэлт, гаалийн байгууллагын зөвшөөрлөөр хяналтын талбай, бүсээс бусад талбайд тавьж, гаалийн байгууллагад шалгуулсан тохиолдолд чингэлгийг зөөвөрлөж гаальд шалгуулсан гэж үзнэ. (хүснэгт 3-ын 1 дүгээр заалтад хамаарна)

7. Чингэлгийг гаалийн үзлэгт шалгуулах зорилгоор доторх ачааг нь буулгах, буцааж ачих үед хэрэглэнэ. (хүснэгт 3-ын 2 дугаар заалтад хамаарна)

8. Вагоны ломбо тасалж, хаалгыг нээх, хаах, дахин түр ломбо зүүх, ачааг ухаж буулгаж, буцааж ачих, дээжинд ачаа авч өгөх, ачааны бэхэлгээг тасалж, өргөж зөөж үзүүлэх г.м ажиллагааг гүйцэтгэсэн тохиолдолд хэрэглэнэ. (хүснэгт 3-ын 3 дугаар заалтад хамаарна)

Б. Гар аргаар

Хүснэгт 4. Ачааг ачих, буулгах ажлын хөлс

ДД	Ажил	Хэмжих нэгж	Ажлын хөлс, төгрөг
1	Бүх төрлийн хайрцагтай, шуудайтай болон боож багласан ачааг ачих, буулгах	1 тонн	5000
2	Ширхэгийн сав баглаа боодолтой цементийг ачих, буулгах	1 тонн	6000
3	Хялбар хагарч гэмтэх шаазан ваар, шил, чулуу болон түүгээр хийсэн эдлэл, цахилгаан бараа, сав баглаа боодол дээр нь мөн "хөмөрч, өнхрүүлж болохгүй", "хялбар гэмтэнэ" гэсэн тэмдэглэл хийсэн ачааг ачих, буулгах	1 тонн	7000
4	Төрөл бүрийн савтай шингэн ачааг ачих, буулгах	1 тонн	5000
5	Тэсрэх, дэлбэрэх аюултай хортой ачааг ачих буулгах	1 тонн	14000
6	Бүх төрлийн машин механизм, тоног төхөөрөмж, сэлбэг, эд ангийг ачих, буулгах	1 тонн	5000
7	Асгаж, овоолж ачдаг нунтаг, нурмаг ачааг ачих, буулгах	1 тонн	5000
8	Тоосго, шохой, альбастр зэрэг барилгын ачааг ачих, буулгах	1 тонн	5000
9	Банз, гуалин, дэр мод, хэрэглээний зах банз, шонгийн мод, фанер, савх, банз, модон байшин, түүний бие анги, үртэс, зоргодос зэрэг модон материалыг ачих, буулгах	1 тонн	5000
10	Бүх төрлийн төмөр, түүгээр хийсэн хийцийн бүтээгдэхүүн (труба, булан төмөр, тор, лист зэрэг)-ийг ачих, буулгах	1 тонн	5000
11	1,5м-ээс урт хэмжээтэй хөрөөдсөн түлээ, түлшний зах банзыг ачих, буулга	1 тонн	5000

дд	Ажил	Хэмжих нэгж	Ажлын хөлс, төгрөг
12	Үр тариаг ачих, буулгах	1 тонн	5000
13	Хүнсний ногоо, жимс жимсгэнийг ачих, буулгах	1 тонн	6000
14	Арьс, шир, нэхийг ачих, буулгах	1 тонн	5000
15	Гэр ахуйн хулдаас, хивс, хивсэнцэрийг ачих, буулгах	1 тонн	5000
16	Зориулалтын бус вагонд ачааг ачих, буулгах	1 тонн	8000
17	Зориулалтын бус хашлагатай машинаас вагонд ачааг ачих, буулгах	1 тонн	8000
18	Зориулалтын бус хашлагатай машинаас зориулалтын бус вагонд ачааг ачих, буулгах	1 тонн	9000

Тайлбар:

- Дээрх ачааны ангилалд багтсан ачаануудыг зориулалтын стандартын сав, баглаа, боодолтой, өргөж, зөөх боломжтой гэж үзнэ. (хүснэгт 4-т хамаарна)
- Ачилт, буулгалтын хөлсийг дараах тохиолдолд 100 хувиар нэмэгдүүлэн тооцно. Үүнд: (хүснэгт 4-т хамаарна)
 - Нунтаг, нурмаг ачаа нь хөлдүү байвал.
- Ачилт, буулгалтын хөлсийг дараах тохиолдолд 50 хувиар нэмэгдүүлэн тооцно. Үүнд: (хүснэгт 4-т хамаарна)
 - Ачилт буулгалтын техникийн шаардлага (баглаа боодолгүй, хайрцаггүй задгай, задарсан эсвэл ачаа илгээгчийн хүсэлтээр ачааны баглааг задалж ачиж байгаа) хангаагүй ачаа;
 - 5000-аас дээш байрын тоотой ачаа.
- Илгээгчийн мэдүүлсэн ачааны жинг үндэслэн бодох ба 1 тонн хүрээгүй жинтэй ачааг 1 тонн ачаагаар бодно. Ачилт, буулгалтын үед илгээгчийн мэдүүлснээс өөр нэр төрлийн ачаа гарах, жин нэмэгдэх тохиолдолд мэдүүлэгт нэмж бичүүлж нийт жингээр тооцно. (хүснэгт 4-т хамаарна)
- Хэрэв хэд хэдэн төрлийн ачилт, буулгалтын үнэлгээтэй ачаа нэг вагонд ачигдсан бол ачааны төрлөөр жинг бүхэлчлэн үнэлгээ тус бүрээр ачилт, буулгалтын хөлсийг бодож, тэдгээрийн нэгтгэсэн дүнгээр нийт үнийн дүнг гаргана. (хүснэгт 4-т хамаарна)
- Зориулалтын сав баглаа боодолтой байх ба 1 байрын ачаа нь ачигч өргөж зөөх боломжтой савлагдсан байна. (хүснэгт 4-ийн 2 дугаар заалтад хамаарна)
- Зориулалтын сав баглаа боодолтой байх ба 1 байрын ачаа нь ачигч өргөж зөөх боломжтой савлагдсан байна. (хүснэгт 4-ийн 9, 10 дугаар заалтад хамаарна)
- Зориулалтын сав баглаа боодолтой байх ба 1 байрын ачаа нь ачигч өргөж зөөх боломжтой савлагдсан байна. (хүснэгт 4-ийн 12-15 дугаар заалтад хамаарна)
- Автомашин тэвш нээгддэггүй эсвэл хэт өндөр, хагас вагоны духны хаалгыг онгойлгож ачаа ачих, буулгах. (хүснэгт 4-ийн 16-18 дугаар заалтад хамаарна).